



I-II/2021

Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 14



Худалдааны салбарын нийт борлуулалт 2021 оны эхний 2 сард 10.7 хувиар өслөө.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2021 оны эхний 2 сард 3.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 324.9 (10.7%) тэрбум төгрөгөөр өслөө. Харин 2021 оны 2 дугаар сард 1.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 104.0 (6.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Худалдааны салбарын нийт борлуулалт<sup>1</sup>, жил бүрийн эхний 2 сард

	2018*		2019*		2020*		2021*		2021* I-II 2020* I-II
	II	I-II	II	I-II	II	I-II	II	I-II	
	тэрбум төгрөг								хувь
<b>Нийт</b>	<b>1 245.0</b>	<b>2 422.2</b>	<b>1 370.7</b>	<b>3 019.0</b>	<b>1 453.0</b>	<b>3 049.1</b>	<b>1 634.9</b>	<b>3 373.9</b>	<b>110.7</b>
Бөөний худалдаа	420.8	831.7	470.0	1 076.5	514.7	1 078.7	595.5	1 249.1	115.8
Жижиглэн худалдаа	824.3	1 590.4	900.8	1 942.5	938.3	1 970.3	1 039.4	2 124.8	107.8

<sup>1</sup> Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо


Худалдааны салбарын борлуулалтын орлогын 2021 оны эхний 2 сард 37.0 хувь нь бөөний худалдаа, 63.0 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2021 оны эхний 2 сард 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 154.4 (7.8%) тэрбум төгрөгөөр өслөө. Харин 2021 оны 2 дугаар сард 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 45.9 (4.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Бөөний худалдааны борлуулалтын орлого 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 170.4 (15.8%) тэрбум төгрөгөөр өслөө. Харин 2021 оны 2 дугаар сард 595.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 58.1 (8.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Худалдааны салбарын нийт борлуулалтын 82.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалт 2021 оны эхний 2 сард 2.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 254.7 (10.1%) тэрбум төгрөгөөр өслөө.

Харин 2021 оны 2 дугаар сард 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 97.5 (6.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 1. Худалдааны салбарын нийт борлуулалт, жил бүрийн эхний 2 сард, тэрбум төгрөг




Зураг 2. Худалдааны салбарын болон Улаанбаатар хотын худалдааны нийт борлуулалт, жил бүрийн эхний 2 сард, тэрбум төгрөг



Өмнөговь аймгийн худалдааны борлуулалт 2021 оны эхний 2 сард 115.5 тэрбум төгрөг болж, аймгуудын (Улаанбаатар хотыг оруулаагүй) борлуулалтын нийт дүнд 19.6 хувийг эзэлж байна.

Зураг 3. Худалдааны салбарын борлуулалт, аймгаар, жил бүрийн эхний 2 сард, тэрбум төгрөгөөр



**Ойлголт, тодорхойлолт:**

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-г оруулна.

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт

бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.

**Эх үүсвэр:** ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ, НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

**Ангилал, код:** Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 5 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн  
газрын дарга Э.Эрдэнэсан  
Утас: (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн  
газрын статистикч Л.Энхбаатар  
Утас: (976-51)-261502

